



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

“Монгол шуудан” ТӨХК-ийн нийтэд санал болгон¹
нэмж гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, 34.1.7, Компанийн тухай хуулийн 42.4, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 112 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2008 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 392 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2012 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 303 дугаар тогтоолууд, “Монгол шуудан” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ТӨХК-ийн нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны тоог нийт 32,373,000 /гучин хоёр сая гурван зуун далан гурван мянга/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэн, тус компанийн гаргасан хувьцааг нийт 98,100,000 /Ерөн найман сая нэг зуун мянга/ ширхэг байхаар үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан нийт 98,100,000 ширхэг “Монгол шуудан” ТӨХК-ийн энгийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг дор дурдсан хуваарийн дагуу хөрвүүлэн бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай:

Өмчлөлийн нэр	Өмчлөлд хөрвүүлэн бүртгэх хувьцааны тоо	Нийт энгийн хувьцаанд эзлэх хувь хэмжээ
Төрийн мэдэлд /ТӨХ/	65,727,000	67%
Олон нийтэд санал болгох (үүнд “Монгол шуудан” ТӨХК-ийн ажилтнуудад хуваарилах 1% орсон)	32,373,000	33%

071783

3. “Монгол шуудан” ТӨХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон захиалгын бүртгэл хийх аргаар анхдагч зах зээлд байршуулж, захиалгын доод үнийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу 140 /нэг зуун дөч/ төгрөгөөр тогтоохыг зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын 2-т заасан нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг нийтэд танилцуулж эхэлснээс хойш ажлын 6 хоногоос доошгүй хугацааны дараа захиалгыг авч эхлэх бөгөөд үргэлжлэх хугацаа нэг сараас илүүгүй байна. Үнэт цаасны захиалга авах хугацаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан үнэт цаасны худалдах үнийг андеррайтер “Гаули” ХХК /Ким Сын Квон/, үнэт цаас гаргагч “Монгол шуудан” ТӨХК /Г.Чинзориг/ нар хамтран тогтоож Хороонд мэдэгдсүгэй.

5. Нэмж гаргаж буй хувьцааг “Монгол шуудан” ТӨХК-ийн нийтэд санал болгон арилжаалах ажиллагааны дүнд төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай 4,532,220,000.0 /дөрвөн тэрбум таван зуун гучин хоёр сая хоёр зуун хорин мянга/ төгрөгийг бүрэн татан төвлөрүүлсэн тохиолдолд нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг амжилттай болсонд тооцохоор тогтсугай.

6. “Монгол шуудан” ТӨХК-ийн нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж дууссаны дараа Хорооны даргаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хоёрдогч зах зээлийн арилжааг нээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

7. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд үнэт цаас худалдсаны орлого буюу үнэт цаас гаргагч “Монгол шуудан” ТӨХК-ийн дансанд байршсан олон нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тус компани хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг шинэчилсэн бүрэлдэхүүнтэйгээр зарлан хуралдуулж, төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг захиран зарцуулах болон удирдлагын бүтцэд өөрчлөлт орох талаар холбогдох шийдвэрийг гаргаж тус Хороонд ирүүлэх хүртэл хугацаанд тусгай дансанд тусгаарлах арга хэмжээ авахыг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

8. “Монгол шуудан” ТӨХК-ийн нийтэд санал болгон худалдсан үнэт цаасыг худалдан авсан хувьцаа эзэмшигчдийн тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхийг хангах зорилгоор Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хурлын зар мэдээг хүргэх тухай журам”-ын 2.5 дахь заалт тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахад үйлчлэхгүй болохыг тогтоож, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах “бүртгэлийн өдөр”-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрийн өмнөх өдөр байхаар тогтоосугай.

9. Тус компанийн нэмж үнэт цаас гарган олон нийтэд санал болгох шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монгол шуудан” ТӨХК /Г.Чинзориг/, “Гаули” ХХК /Ким Сын Квон/-д тус тус үүрэг болгосугай:

1/ энэхүү тогтоолын 1-д заасан нийтэд санал болгон 32,373,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах тухай үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн холбогдох журмын дагуу танилцуулгыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж дууссанаас хойш холбогдох журмын дагуу 10 хоногийн дотор үнэт цаасны гүйлгээний талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд ирүүлэх;

3/ үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох баримтын хамт Хороонд ирүүлэх;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь ирүүлэх, 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалийн кодекс”-ийг мөрдөж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах.

10. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН